

Дундговь аймгийн Өлзийт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны үйл ажиллагааны тайлан

2016-12-19

Рашаант

Сумын ИТХ нь НӨУЁБ-ын хувьд Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан эрхийнхээ дагуу сумынхаа нийгэм, эдийн засаг, байгаль орчны талаар баримтлах бодлогыг ИТХ болон түүний чөлөөт цагт Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэнд хяналт тавьж ажиллаж ирлээ. 2016 онд ИТХ-аар бүрэн эрхийнхээ дагуу төлбөр,хураамж тогтоож төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн тодотгол хийж хэмнэлттэй зарцуулах, Орон нутгийн ээлжит сонгуулийг явуулах, сонгуулийн үр дүнг батлах, хууль тогтоомжийг сурталчилах, иргэдийг мэдээллээр хангах чиглэлээр ажиллаж, бодлого боловсруулан батлаж хэрэгжүүллээ.

Нэг. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан

Сумын ИТХ нь 2016 онд ээлжит бус хурал 1, ээлжит 3 хуралдаан хийж /энэ хуралдаантай 4 болж байна/ 2016 оны “Төсвийн тодотгол”, “Цэвэр усны төлбөр тогтоох тухай”, “Хог хаягдлын төлбөр тогтоох тухай”, “Төрийн өмчийн байрны түрээсийн тухай”, “Сумын 9 гайхамшигийг батлах тухай”, “Сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлах тухай”, зэрэг эдийн засаг, байгаль орчны бодлогын асуудлуудаас гадна хурлын бүтэц бүрэлдэхүүн, дотоод зохион байгуулалтын чанартай асуудлуудыг хэлэлцэж баталлаа. ИТХ нь өнгөрсөн хугацаанд 4 хуралдаан хийж 3 хуралдаан 100 хувийн ирцтэй, 1 хуралдаан 57 хувийн ирцтэй хуралдааны дундаж ирц 90 хувьтай байсан байна. ИТХ-ын хуралдаануудад давхардсан тоогоор оролцсон төлөөлөгч 91 оролцоогүй төлөөлөгч 14, тасалсан төлөөлөгч 3 байна. ИТХ-аас 71 заалт бүхий 16 тогтоол гаргасан байна. Төлөөлөгчдөөс 20 санал шүүмжлэл гарснаас хурлын шийдвэрт 16 саналыг тусгасан байна.Тогтоолыг агуулгаар нь ангилж үзвэл Төсөв хөрөнгө баталж тодотгосон 2, Төлбөр, түрээсийн хэмжээ тогтоосон 3, газрыг тусгай хамгаалалтаас чөлөөлсөн 1, төлөвлөгөө баталсан 1, байгаль орчин 1, бусад 8 тогтоолыг гаргасан байна. Эдгээр тогтоолоос хэрэгжилтийг тооцож үзэх шаардлагатай заалтуудыг тооцож үзвэл 1 заалт биелээгүй /АМГ-т кадастрын бүртгэл хийлгэх/, төлбөртэй холбоотой заалтууд дутуу хэрэгжиж байна.

ИТХ-ын 2016 оны 09 сарын 30-ны өдрийн 07 тоот тогтоолоор сумын “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г баталсан нь сумын байгалийн бүх төрлийн нөөц баялагийн судалгаа гаргаж үнэлэх, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, бэлчээрийг усжуулах, ногоон байгууламж буй болгох, байгалд ээлтэй үйлдвэрлэл явуулах, иргэд, өсвөр үеийхэнд экологийн боловсрол олгох, цөлжилтийг сааруулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх зэргээр иргэд эрүүл аюулгүй орчинд, ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх, тогтвортой хөгжлийг

хангах дунд хугацааны хөтөлбөрийг анх удаа гаргалаа. Хөтөлбөрийг боловсруулахад “Хил хязгааргүй алхам” ТББ, сумын ажлын хэсэг, иргэдийн төлөөлөл, Хулд, Луус сумдын төлөөлөл оролцсон.



Төлөвлөгөө боловсруулж, бүлгүүдээс
Төлөвлөгөө боловсруулсан



санал авч байгаа нь

ажлын хэсэг

2.Тэргүүлэгчдийн хурал, шийдвэрлэсэн асуудлууд

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид 2016 онд 13 удаа хуралдаж 62 заалт бүхий 33 тогтоол гаргасан байна. Тогтоолыг агуулгаар нь ангилвал хурлын тов 5, зөвлөл, ажлын хэсэг, комисс байгуулах 3, уул уурхайгаар эвдэгдэж эзэнгүй орхигдсон газрын нөхөн сэргээлт 2, Сонгууль зохион байгуулах 5, Шагнал 6, Хөрөнгө актлах, бүртгэх 3, Үндсэн чиглэл, төлөвлөгөө батлах 2, бусад асуудлаар 6 тогтоол гаргаж 8 тэмдэглэлээр шийдвэр гаргасан байна. 2016 оны хяналтанд авч биелэлтийг гаргаж байх 16 тогтоолын биелэлтийг гаргахад 15 нь биелэгдсэн, 1 дутуу биелэлттэй байна. БОМ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хөрөнгө тусгуулах ажил эхлэл төдий байна. ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор ??? байгууллагын ??? нэр төрлийн ??? төгрөгний хөрөнгийг акталж, ??? байгууллагын ??? нэр төрлийн ??? төгрөгний хөрөнгийг төрийн өмчид бүртгэх шийдвэр гаргаж хэрэгжсэн.

Ойрын үед шийдвэрлэвэл зохих тулгамдаад байгаа цаг агаарын бэрхшээлээс шалтгаалж гадны аймаг, сумаас орж ирж оторлож байгаа малчдаас төлбөр хураамж авах эсэх, нэг малчин айл өрх хэдэн бууцтай байвал зохимжтой байх, автотехникийн үзлэгийг хэдэн сард хийх талаар 6 багийн 210 өрхийн төлөөллөөс санал асуулга авсан. Саналын дүнг нэгтгэж дээрх асуудлаар хуульд нийцсэн журам гаргаж батлуулахаар төлөвлөж байна.

Өлзийт сумын малчин өрхөөс бэлчээрийн төлбөр, бууцны тооны талаар авсан саналын дүн

БАГ	САНАЛ	Малчин өрх хэдэн бууц эзэмшивэл зохистой вэ?		Отроор орж ирсэн малаас төлбөр авах шаардлагатай юу?			Отроор байх хугацааг тогтоох хэрэгтэй юу?		Автотехникийн үзлэгийг аль сард авах вэ?		Автотехникийн үзлэгийг хаана авах вэ?	
		1-2	Тоо тогтоох шаардлагагүй	шаардлагагүй	Шаардлагатай		тогтооно	тогтоохгүй	4-р сард	5-р сард	Буянтын төвд	Сумын төвд
			Олон малд илүү авах	Малын тоо харгалзахгүй								
1	36	16	5	10	22	4	25	12	1	35	13	24
2	73	38	20	31	12/18	8	28	40	28	38	61	8
3	19	11	7	2	8	5	4	5	6	10		
4	33	22	10	17	5/3	4	15	18				
5	49	22	18	12	6/16	16	34	15				
НИЙТ	210	109	60	72	17/67	37	106	90	35	83	74	32

Малчдаас ирүүлсэн саналыг дүгнэж үзэхэд санал өгсөн малчдын 51 хувь нь малчин өрх 1-2 бууцтай байх, 28.5 хувь нь бууцны тоо тогтоох шаардлагагүй гэсэн бол 57.6 хувь нь отрын малчдаас төлбөр авах шаардлагатай, 34.2 хувь нь төлбөр авах шаардлагагүй гэж үзжээ. Отроор байх хугацааг 50.4 хувь нь тогтоох нь зүйтэй, 42.8 хувь нь тогтоох шаардлагагүй гэж хариулжээ.

2016 оны онцлог нь улс, орон нутгийн сонгуулийн жил бөгөөд ИТХ-ын Тэргүүлэгчдээс улс, орон нутгийн сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэр, төв, сонгогчдын тоо, мандатын тоог тогтоож сонгууль явуулах нөхцлийг бүрдүүлж өгсөн. Тэргүүлэгчдээр СХС-ийн зарцуулалт, эргэн төлөлтийг удаа дараа хэлэлцэж үүрэг даалгаврыг өгснөөр шүүхийн эвлэрүүлэн жуучлах журмаар хэлцэгдэж хугацаат үүрэг өгөгдөөд байна. Энэ ажлын хүрээнд СХС-ийн зээлийн дээд хэмжээ, Төсөл сонгон шалгаруулах зөвлөл, хяналтын ажлын хэсгийг шинэчлэн баталлаа. Зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаа нь мөнгөн хуримтлал үүсгэж шинэ төсөл хэрэгжүүлэн ажлын байр гаргах, буй болсон үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих, тогтвортой ажиллуулах нөхцлийг бүрдүүлэхэд муугаар нөлөөлж байгааг анхаарах хэрэгтэй.

ИТХ-ын Тэргүүлэгчдээс 3-р багийн нутаг болох 3 газарт уул уурхайн зориулалтаар эвдэгдэж эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх зөвшөөрөл 3 компанид олгож 1 компани 10 га газрыг нөхөн сэргээж хүлээлгэн өгсөн байна.

2016 онд хийх ажлын төлөвлөгөөнд 40 асуудал төлөвлөснөөс 3 асуудал биелээгүй /Иргэний танхим ажиллуулах, Нутгийн удирдлага сонинд мэдээлэл өгөх, байгууллагуудад хяналт шалгалт хийх/ бөгөөд 90 хувийн биелэлттэй байна. ИТХ-ын ажлын албанаас 7 хоног бүр ажлаа төлөвлөж 7 хоногийн мэдээ, сарын шуурхай мэдээг гаргаж өгдөг. “Сумын БИНХ-ын даргын ажил дүгнэх журам”-ын дагуу БИНХ-ын дарга нарын ажлыг сар бүр дүгнэж урамшуулал олгож байна. Засгийн газрын төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах журмын дагуу ИТХ-ын тэргүүлэгчдээс гаргасан тогтоолын дагуу БИНХ-ын даргын цалинг улиралд нэг удаа сард авч байсан цалингийн хэмжээгээр ажлын үр дүнг харгалзан олгож байна. Тэргүүлэгчдийн ажиллах журамд заасан үзүүлэлтээр ажлыг нь хагас бүтэн жилээр дүгнэж зарим тэргүүлэгчдэд урамшуулал олголоо. БИНХ-ын дарга нар БИНХ-ын үед ажиллахаас бусад үед иргэдтэйгээ ажиллахгүй, тайлангаа өгөхгүй, санаачлага гаргахгүй байгаа нийтлэг дутагдал арилахгүй байна.

Ажлын алба өнгөрсөн 4 жилд 3.5 сая төгрөгний эд хөрөнгө авч, 1 сая төгрөгөөр өрөөний тохижилт хийж ажлаа хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлсэн. Эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтаа сайжруулж анхан шатны бүртгэлийг зааврын дагуу хөтлөн аудитийн шалгалтаар эд хөрөнгөтэй холбоотой зөрчил гараагүй.

Улсын архивын үзлэгийг угтаж бичиг хэрэг, архивын ажлыг стандартын дагуу хийж төрөлжүүлэн сумын архивт шилжүүлсэн. Улсын архивийн үзлэгээр зөрчил гараагүй. 1992 оны Засаг захиргааны бүтэц зохион байгуулалтаас хойш 2016 он хүртэл ажиллаж байсан ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарын товч намтар, ажлын амжилтыг гаргаж НӨУЁБ-ын 25 жилийн ойгоор гарах номонд оруулахаар хүргүүлсэн. 2016 онд төрийн дээд одон “Алтан гадас” одонгоор 3 хүнийг, Цэргийн гавъяаны улаан тугийн одонгоор 1 хүнийг, “Алдарт эх” 1-р одонгоор 2, 2-р одонгоор 5 хүнийг тодорхойлж, “Алтан гадас” одонгоор 1, “Алдарт эх” 1-р одонгоор 2, 2-р одонгоор 5 эх шагнагдлаа. ИТХ-ын Тэргүүлэгчдийн 04-р тогтоолоор сумын соёлын төвийг ардын жүжигчин Н.Дагийранзын нэрэмжит болгохоор хүсэлт гаргаж аймгийн ИТХ-ын 17-р тогтоолоор МУАЖ Нямын Дагийранзын нэрэмжит соёлын төв болсон. Ахмадын баяр, Цагаан сараар байгууллагын харъяат 3 ахмадад хүндэтгэл, ар гэрийн гачигдал гарсан 3 төлөөлөгчид дотоод журмын дагуу мөнгөн тусламж үзүүлсэн.

Ажлын албанд 31 албан бичиг ирж хариутай 11 бичгийн хариуг өгсөн ба 30 бичиг явуулсан байна. Ирсэн явсан бичгийг цаасаар болон цахим програмаар үйлдэж байгаа нь цаг алдахгүй байж удирдлагаас хяналт тавих боломжтой болсон. Шинээр сонгогдсон 21 төлөөлөгчийн ХОМ-ийг 2015 оны байдлаар маягтын дагуу авч нэгтгэн баталгаажуулж АТГ-т хүргүүлсэн. АТГ-ын зөвлөн туслах үйл ажиллагаанд хамрагдаж төлбөр тогтоох тухай тогтоол Тэргүүлэгчдийн эрх мэдэл хэтрүүлэн гаргасан зөрчил гарч тогтоолыг хүчингүй болгож ИТХ-аар нөхөж тогтоол гарган зөрчлийг хугацаанд нь арилгаж АТГ-т мэдэгдсэн.



ОНХС, СХС-ийн үйл ажиллагааны талаар Тэргүүлэгчдийн хуралд мэдээлэл хийлгүүлж зохих арга хэмжээ авсныг дээр дурьдсан.

Ажлын албанд 20 санал, хүсэлт ирсэнээс 1 хүсэлт бүрэн биелээгүй. Төрийн мэдээлэл, Нутгийн удирдлага, аймаг, сумын сонинг захиалж ажилдаа хэрэглэж байна.

Гурав. Сургалт, сурталчилгааны ажлын талаар

Монгол улсын хууль, аймаг, сумын ИТХ-аас гарсан тогтоол, шийдвэрийг 6 БИНХ, мэдээллийн цагаар иргэдэд яриа, таниулга хэлбэрээр 32 удаа хийж давхардсан тоогоор 1200 иргэн хамрагдсан. ИТХ, Тэргүүлэгчдээс гарсан шийдвэр, цаг үеийн ажлыг мэдээллийн самбараар ил тод тогтмол мэдээлж, сумын сонин Хурал.mn сайтад зарим мэдээг тавьсан.

ИТХ-ын тэргүүлэгчид, ажлын албанаас 2012-2016 онд ИТХ-аас хэрэгжүүлсэн бодлогын шинж чанартай бүтээн байгуулалттай холбоотой ажлыг номонд оруулж сумын нийт айл өрхөд тараагдсан. БОМ-ийн төлөвлөгөө боловсруулах сургалтыг “Хил хязгааргүй алхам” ТББ-тай хамтран иргэд, ТББ, Төрийн албан хаагчдын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан.



Уламжлал ёсоор Шинэ үндсэн хууль батлагдсаны 24 жилийн ойгоор төрийн далбаа залах ёслол үйлдэж, ЕБС-ийн сурагчид иргэний андгай өргөсөн. Энэ үеэр хүүхэд, насанд хүрэгчдийн дунд шатрын тэмцээн, нийт иргэдийн дунд үндсэн хуулийн сэдвээр “Центавр” тэмцээн явууллаа. Мөн ЗДТГ-тай хамтран төрийн захиргааны албан хаагчдын тангараг сэргээх ёслолыг хийсэн нь шинэлэг ажил болов.



“Дэлхийн зөн” ОУБ-тай хамтран сумын төвийн иргэдийн дунд “сайжруулсан ариун цэврийн байгууламж” 1 сарын аяныг тусгай удирдамжийн дагуу зохион байгуулж дүнг гарган шагнал урамшуулал олгосон. Энэ талаарх 2 сургалтанд 50 өрх хамрагдаж 4 өрхийг шагнаж урамшуулсан.



Ариун цэврийн байгууламжаа сайжруулах гарын авлагыг нийт өрхөд тарааж 15 өрх өөрийн нөөц боломжоор бие засах газраа сайжруулсан.

Хөдөлмөр, халамж хариуцсан ажилтантай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах олон улсын өдөр”-ийг тусгай төлөвлөгөөний дагуу явуулж холбогдох хуулиар яриа, таниулга хийж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд “АХА”, “Караоке” тэмцээн зохиож 1 баг, 1 оролцогчийг



шалгаруулж шагнал гардууллаа.

Энэ аянаар сургуулийн хүүхдийн дунд “сайн үйлс” аяныг зохион байгуулсан. Аяны ажиллагааг сумын сонин, АС сүлжээгээр мэдээлсэн.

Байгууллагуудын өмчид бүртгэлээр хяналт тавьж шинээр олсон, актлах шаардлагатай хөрөнгийн талаар үүрэг өгч ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлсэн. Байгууллагын санхүүг ил тод байлгаж мэдээллийн самбарт төсвийн хэлбэлзлийн сарын тайланг тогтмол мэдээлж, шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох сайтад хугацаанд нь байршуулж байна.

Дөрөв. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар

??

Тав.Дүгнэлт

2016 онд ИТХ-ын тэргүүлэгчид, ажлын албанаас орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн тодотгол хийх, нөхөн сэргээлт хийлгэх, орон нутгийн сонгууль явуулах зэрэгт эрх зүйн орчинг бүрдүүлэх ажлыг хийсэн байна. Төлөөлөгчдийг баг, тойрогт нь ажиллуулах, ажлын хороодыг ажиллуулах тал дээр дутмаг ажилласан байна.

Цаашид тавих зорилт:

- 1. Төлөөлөгчдийг чадавхижуулах**
- 2.**

